

СОЁЛЫН ДОВТОЛГОО №7 Урдуур дайрахыг овсгоо гэж бvv андуур

"ГАНЦХАН ЮМ АСУУНА" ГЭЧИХЭЭД...

Хэдэн жилийн омно эрvvл мэндийнхээ даатгалын vр шимийг хvртчих санаатай дvvргийн нэгдсэн эмнэлэг дээр дугаарлаж суув. Нэлээн ч хvнтэй байсан. Тэр вeд донгож л цахим картыг ашиглах тухай яриа гарч байсан ve. Одоогийнх шиг vзvvлэх цаг, нэр эмчийн хаалганы хажуугийн дэлгэц дээр гарч эсвэл сувилагч нэрийг тань дууддаг байсангvй.

Хvмvvс ч орж гараад л, цаг гаруй дугаарлаж зогсов. Гэтэл нэгэн эмэгтэй “Би ганцхан юм асуугаад л болоо” гэж ороод бараг бvтэн биеийн vзлэгт ороод гарсан даа. Тэр цагаас хойш “ганцхан юм асуух” хvсэлтэд vгvй гэж хариулдаг болсон юм.

Иймэрхvv явдал улсын байгууллагатай холбоотой вйлчилгээ авах вeд нэлээн тохиолдоно. Харьцангуй ихэнх нь дугаар авдаг болсон ч хараахан нэвтрээгvй газрууд их бий. Тийм тохиолдолд “нэг юм асуух” гээд нэлээн ажлаа бvтээчихээд гардаг хvмvvс мэр сэр бий.

Угаас манайхан дугаарлаж сураагvй ард тvмэн гээд хэлчихэд буруудахгvй. Дугаар дайрч, нэг хvний омно орж байвал тvvнийгээ овсгоо самбаатай гээд ойлгочихсон хvмvvс их. Дугаарлах гэдэг нь нэг нэгнийхээ араас шилийг нь харж зогсоод ээлж дараатайгаар вйлчлvvлэхийг хэлдэг бол манайд дахин нэг эгнээ vвсгээд хэн нь тvрvvлж орохоо vзэх “уралдаан” гээд тодорхойлж болж байгаа юм.

ГЭНЭТ ШАХАЖ УРДУУР ОРОХЫГ ЖОЛООЧИЙН ЧАДВАР ГЭХГҮЙ БҮДҮҮЛЭГ
ҮЙЛДЭЛ ГЭНЭ

Энэ зангаа авто зам дээр ч гаргана. Манай зам дээр ер нь эгнээ байр тэмдэглэсэн цагаан зураас байх ч хэрэггүй гээд хэлчихвэл буруудахгүй. Эгнээ байраараа явдаг соёлтой жолооч одрийн од шиг. Нэг эгнээтэйд хоёр, хоёрт гурав, гуравт дорвон эгнээ үүсгээд л боороороо наалдчих гээд л зогсоно. Хажуугаар чинь шахаж орж ирээд урд чинь гарчихвал зорилго нь биелж байгаа мэт аашилна. Ероос хэдхэн секундын толоо л заавал урд нь гарах гэж улайрдаг хүмүүс нь энэ үйлдлээ овсгоо самбаатай жолоочийн чадвар гээд ойлгочихсон байдаг гэлтэй. Гэтэл яг үнэндээ энэ чинь бүдүүлэг үйлдэл юм.

Зам дээр бухимдахгүйн тулд дохио огсон нэгнийг урдуураа оруулж, чухал шаардлагагүй бол хэдхэн секундын толоо эгнээ байр сэлгэн, хажуу эгнээнийхээ завсраар чихэх хэрэггүй.

"УРДУУР ДАЙРАГСАН"-ЫН ШИНЖ ТЭМДГҮҮД

За тэгээд дэлгүүр хоршоо, элдэв үйлчилгээ авах үед урдуур дайрагсад дараах байдлаар бусдыг бухимдуулна. Жишээлбэл,

- Дараалал, дугаарыг тэд тоохгүй. Хажуу дахь хүнтэйгээ ярьж байгаа дүр эсгэж байгаад л таныг гэнэ алдах тэр мочид "хооп" гээд л урдуур чинь орчихно.
- Эсвэл олон эгнээний алинд нь ч биш голоор нь явж байгаад л шууд дараалалд гулсан орно. Таныг шаардлага тавих үед энд байсан гэж мэлзэнэ.
- Бас нэг арга нь араас шахах. Урд талын хүнтэй нийлтэл шахна. Араас ёворно. Мор дэрлээд хэвтэх нь үү гэлтэй наалдана. Эцэст нь та урдуур дайрагчийн энэ байдалд эвгүйцэн зай гаргаснаар тэд дахиад л "хооп" гээд урдуур орчихно доо.
- Таныг омнох хүнээ гарахаар нь аажуу тайван орно доо гээд сандал дээр сууж байх хооронд гар утсаараа ярьж байгаа мэт болж энэ тэрүүгээр явж байгаад гэнэт орох нь бас л тэдний нэг арга.
- Оор нэг хэлбэр нь "чих хатуу" болж жвжиглэх. Таныг шаардлага тавьсан ч сонсоогүй царай гаргана. Гүрийсээр байгаад л урдуур дайрахдаа л дайрдаг нэг хэсэг хүмүүс байна.
- Ууртай урдуур дайрагч. За тэд бол ёстой юу ч гэж хэлээд нэмэргүй. Таныг "А" гэхэд "Б, В, Г" гээд 35 үсгийг дуустал хэлээд загнаж дайрч байгаад урдуур чинь орж ажлаа бүтээгээд явчихна тэр дээ. Энэ үедээ оорийнхоо ямар завгүй, бачим явааг хэлэх нь тэр.

Гэх мэтчилэн урдуур дайрахыг овсгоо самбаатайн илрэл гэж бүү эндүүрээрэй. Дугаарлаж сурна гэдэг таны оорийгоо бас бусдыг хүндэтгэж буйн нэг илэрхийлэл, СОЁЛ

ЮМ шvv. Таны цаг алт шиг vнэтэй байж болох ч бусдын цаг ч бас алттай зvйлрлэхvйц vнэтэй гэдгийг битгий мартаарай. Таны ажил яаруу бол бусдын ажил ч бас цаг нартай.

Олонтойгоо хамт амьдарна гэдэг угаас хvндлэл, соёл шаардсан ажил учраас урдуур дайрах нь угаас бvдvvлэг хvний вйлдэл гэдгийг ойлгох хэрэгтэй.

СОЁЛЫН ДОВТОЛГОО №8 Үйлчилгээ уур бухимдал бус талархал дагуулах ёстой.

Соёлын довтолгоо хичээл долоон дугаарын турш иргэдэд чиглэсэн мэдээллийг хvргэсэн. Харин энэ удаад бид вйлчилгээний байгууллагуудад зориулсан бага боловч хэрэг болохуйц мэдээллийг хvргэхээр бэлтгэлээ.

Манайд аливаа вйлчилгээг сэтгэл ханамжтай авна гэдэг ихэнхдээ хэцvv. Таксинд суухаас эхлээд л хоолны газар, дэлгvvр хоршоо гээд олон торлийн вйлчилгээнээс гомдол, бухимдалтай тулгарснаа тооч гэвэл нэлээн хэдэн хуудас болох байх.

Угтаа бол вйлчилгээ гэдэг хvний хэрэгцээг хангах ажил. Үvдээр орж ирсэн цагаас нь эхлээд л найрсаг, халуун дотно харилцаагаар угтаж, хэрэгтэй зvйлийг нь хийж огоод гаргадаг байх ёстой. Гэвч энэ vүргээ ухамсарладагvй вйлчилгээний байгууллага, иргэд олон байгаа нь харамсалтай. Тэгвэл тэд ямар алдаа гаргадаг талаар цоохон vгэнд багтаая.

ҮЛ ТООМСОРЛОХ

Хамгийн тvрvvнд вйлчилгээний байгууллагын гаргадаг алдаа бол vл тоомсорлох. Ихэнхдээ хоолны газар, дэлгvvр энэ алдааг гаргадаг. Үйлчлvvлэгчийг харсан ч хараагvй царайлж, заавал “зоогч оо”, “худалдагч аа” гэж дуудуулах, гуйлгах гэдэг. Үйлчлvvлэгч

нэгэнт танайхыг сонгоод ирсэн тохиолдолд та бvх анхаарлаа тэдэнд хандуулах хэрэгтэй. Бас анхаарал хандуулж, бараагаа тайлбарласан гээд заавал авах ёстой мэт харьцаж болохгvй. “Авахгvй бол яах гэж асуусан юм” гэдэг огvvlбэр худалдан авагчийг эргэлт буцалтгvй цааш нь тvлхдэг гэдгийг санахад илvvdэхгvй. Та хэдий чинээ бvтээгдэхvннийхээ давуу талыг тайлбарлаж, таниулна тодий чинээ худалдан авагчид сэтгэгдэл торvvlдэг.

Анхаарал хандуулж, бараагаа тайлбарласан гээд заавал авах ёстой мэт харьцаж болохгvй

“ИНЭЭЖ ЧАДАХГҮЙ БОЛ ДЭЛГҮҮР НЭЭХ ХЭРЭГГҮЙ”

Товийн дvврэгт байрлах, хvмvвсийн мэдэх нэгэн газрын зоогч дахин дахин захиалга огч байна хэмээн уурсаж, нэг мор захиалгаа ог хэмээн вйлчлvвлэгчээ загнасан хогтэй ч юм шиг эмгэнэлтэй ч юм шиг явдал болсон удаатай. Тухайн вйл явдлын эзэн, “загнуулдаг” хэсэг ноход дахин тэр газар орох нь битгий хэл, нэрийг нь ч дурсаагvй талаар ярьж байв.

Инээмсэглэж, эелдэг зан гаргаж харьцаагvйн гор нь эргээд вйлчлvвлэгчээ алдахад хvргэсэн жишээ энэ. Танайхыг гээд зориод ирсэн хvмvвстэй эелдэг дотно харилцаж, инээмсэглэлээр угтаж, талархлаар vддэг байхыг зовлое. “Инээж чадахгvй бол дэлгvвр нээх хэрэггvй” гэж vгийн утга энэ.

ТООЦООНЫ АСУУДАЛ

Орчин вед тооцоо хийх боломж вй олноороо гарчихсан. Гэтэл vвнийг ашиглахгvй хэрэглэгчийг бухимдуулдаг газрууд бий. Таксинд бол монго задлахгvй гэх, худалдааны газар мобайл банк, посын машингvй гэх “МЭО тайлбар”-аа одоо зогсоох цаг нэгэнт болжээ. Олон торлийн толборийн системийг нэвтрvвлж, вйлчлvвлэгчийг хvндрvвлэхгvй байх шийдлийг аль болох эртхэн нэвтрvвлээрэй.

Мон компьютер гацдаг, удаан хэвлэдэг гэх мэт шалтгаан тоочилгvй и-баримтаа

нэхvvлэлгvй огч байгаарай.

ЭЕЛДЭГ ХАРЬЦВАЛ ЭЛЭГ БАРИХ ГЭЖ ҮЗНЭ

Манай вйлчилгээ vзvvлдэг байгууллагууд хэрэглэгчийн гомдолд чин сэтгэлээсээ уучлалт хvсч, залруулдаг нь бас л ховор. Хэдийгээр санал хvсэлтийн утас ажиллуулдаг газрууд олон ч гомдол мэдvvлэх гэж залгаад улам уурсаад дуусах нь элбэг. Та гомдлоо эелдгээр тавьбал таны буруу болгоод онгорох нь элбэг тул шууд л ууртай ярих хэрэг гарна.

Ариун цэврийн ороо гэдэг зовхон биеийнхээ илvvдлийг гаргах бус амс хийж, сэргээд гарах хэсэг байдаг

Таны vзvvлсэн вйлчилгээний талаар санал гомдол гаргавал тvvнийг нь эвтэйхэн шиг шийдэхийг хичээ, тэднийг аргаа бартал нь бухимдуулах хэрэггvй. Уучлалтыг чин сэтгэлээсээ гуйж сурах хэрэгтэй. Бас утсаар вйлчлvvлэгчтэй ярьж байгаа тохиолдолд бохь хэзээ ч зажилж болохгvй, тэр тусмаа дугаргаж бvр болохгvй шvv.

АРИУН ЦЭВРИЙН ОРОО

Зов хvний вйлдэл нvднээс далд ч зов гэдэг шиг ариун цэврийн ороо ямар байх нь тухайн байгууллага вйлчлvvлэгчээ хэрхэн хvндэтгэж байгаагийн илэрхийлэл гэж болно. Ариун цэврийн ороо гэдэг зовхон биеийнхээ илvvдлийг гаргах бус амс хийж, сэргээд гарах хэсэг байдаг. Тиймдээ ч хvvхэдтэй ээжvvд, хогшин настай хvmvvc, хогжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай хэрэгсэл байхгvй, внэр танар гэж ороод хам хум хонгороод гарахаас оор арга vгvй газрууд их. Томоохонд тооцогдох их дэлгvvрт ч ийм дvр торх байдаг нь харамсалтай.

Гэхдээ ороод нvрний будгаа сэргээж, vс зvсээ янзлах, хvvхэд хуурайлах тусгай ширээтэй ариун цэврийн ороотэй дэлгvvр бас байна аа, байна. Бусад газарт vлгэр болох болов уу гээд Polaris их дэлгvvрийн ариун цэврийн ороог танилцуулж байна. Үнэхээр л жижиг зvйлд хvртэл анхаарал хандуулж тав тухыг хангаж чадсан газар Улаанбаатарт нэгээр нэмэгджээ. Япон бараа, япон вйлчилгээг бvх зvйлдээ шингээсэн вйлчилгээнээс нь

мэдрэгдэж байлаа.

Бас нэгэн жишээ, дээр дурдсан вйлчилгээ гэдэг хvний хэрэгцээг хангах ажил. Үvнийг батлах бас нэгэн зургийг сонирхуулж байна. Японы Акасака дvврэгт байрлах зоогийн газрын зоогч эмэгтэй вйлчлvллэгчээ хэрхэн хvндэлж байгааг та энэ зургаас харж болно. Зоогч эмэгтэй бага зэрэг нуруулаг учраас ирсэн зочдыг хэт олийлгож харуулахгvй гэсэндээ захиалга авах бvртээ ийн овдоглон сууж байсан нь нvдэнд содон туссан тул зургийг нь ийн авсан хэрэг.

Алхам тутамдаа л бид ямар нэг вйлчилгээг авч байдаг. Харин тэр вйлчилгээг харамсаж, бухимдаж авахгvй байхад вйлчилгээний байгууллагын ажилтан, эрхлэгч таны хувь нэмэр чухал юм шvв. Инээмсэглэл, талархал хэзээ ч муу зvйл дагуулдаггvй.

СОЁЛЫН ДОВТОЛГОО №9 Сайн байна уу, баярлалаа, уучлаарай, зvгээр, баяртай

Дээрх vгсийг хэлж заншил болоорой. Цоон жишээ дурдъя.

Сайн байна уу?

Францад байдаг ах маань хэдэн жилийн омно Монголд ирчихээд “еронхийдоо л зандарч харьцах юм аа, ажил хооцолдоод явахад загнуулсаар байгаад таарах юм” гэж билээ. Харин нэг удаа толгой сэгсрэн инээсээр орж ирлээ. Яасан гэтэл “орцны жижvвр шал угаагаад байхтай таарлаа. Сайн байна уу гэтэл оодоос том харснаа “овчтэй хог вэ” гэнэ ээ намайг” гэсэн юм.

Гэхдээ сvвлийн вед “ахиц дэвшил” нэлээд гарч байгааг дурьдах хэрэгтэй. Хэдхэн жилийн омно таксинд ороод “сайн байна уу” гэхэд оодоос “хаашаа явах юм” гэж мэндэлдэг байсан бол одгоо хариу мэндлэх, эсвэл тvрvвлж мэндчилдэг болж. Маш сайн тал.

Ялангуяа торийн албан хаагчид болон вйлчилгээний байгууллагынхан иргэдтэй эелдэг харьцаж, дээрх vгсийг амны уншлага мэт хэлж занших нь зvйтэй.

Уучлаарай

Харин автобусанд эсвэл оор хаа ч юм хvний хол дээр гишгэчихээд оодоос гайхсан байдалтай том харах, “оо” гээд онгорох нь элбэг. Уг нь бол “уучлаарай” гэж хэлэх ёстой юм. Харин ногоо этгээд “уучлаарай” гэхэд нь ихэрхэн цихэмхийх биш “зvгээр” хэмээн хариу барих ёстой. Санамсаргvйгээр хvний хол дээр гишгэх нь байх л асуудал богоод vвнд уурлаж уцаарлах шаардлагагvй.

Мон хvнийг санамсаргvйгээр гудманд морлох, гараа дэлгэх ведээ цохих, всээ задгайлан шидэхдээ нvврийг нь ороолгох, хувцсаа хэт далайн омсох ведээ бусдыг шавхуурдах гэх мэт вйлдлvвдэд бvгдэд нь та тухайн хvнээс уучлалт гуйх ёстойгоо битгий мартаарай.

Тvвнчлэн арга хэмжээнээс хоцрох вед ч та бусдын внэт цаг хугацаанаас хумсалсан тул уучлалт гуйх учиртай. “Үнэт” гэдэг нь тэр хугацаанд тухайн хvн олон ажил амжуулж

болох байсан, үгвйдээ гэхэд хайртай хүмүүстэйгээ хамт цагийг таатай онгорүүлэх байсан бол таныг хүлээн хий дэмий бухимдаж суусан гэсэн үг юм.

Баярлалаа

Бусдад талархаж сураарай. “Баярлалаа” гэдэг нь зовхон танд бэлэг дурсгалын зүйл гардуулахад хэлдэг үг биш. Танд хаалга онгойлгосон, суудал тавьж огсон, зам талбай зайчилж огсон хүмүүст, зам тавьж огсон жолоочид гээд бүхэнд баярлаж талархснаа илэрхийлж байгаарай. Энэ нь нийгэмд эерэг уур амьсгалын торүүлэх тодийгвй ногоо хүнд дахин эелдэг, зов вйл вйлдэх нохцолийг бүрдүүлдэг байна.

Баяртай

Дараа инээмсэглэн уулзах шалтгаан гаргахын тулд “баяртай” гэдэг үгийг хэлж заншаарай. Хэн нэгний урилгаар аливаа арга хэмжээнд уригдан очсон бол явахдаа заавал энэ үгийг хэлэх нь зүй. Яасан нь мэдэгдэхгвй алга болох нь бүдүүлэг. Ирснээ мэндчилэн хэлж, явж буйгаа ч мэдэгдэн илэрхийлэх нь соёлт хүний нэг шинж юм.

Харилцаанаас харилцаа үүснэ гэдэг. Юу тарина түүнийгээ хураана ч гэдэг. Нэг одор та эелдгээр инээмсэглэн, багахан тэвчээр гарган, заримдаа хүлээцтэй хандаж дээрх үгсийг хэлж, бусадтай эелдгээр харьцаад үзээрэй.

Хотын хүн танд амжилт хүсье.

СОЁЛЫН ДОВТОЛГОО №10 “Манай гэр л цэвэрхэн бол орц хамаагвй” гэвэл ТОМ ЭНДҮҮРЭЛ

Орцны үүдэнд, лифтэн дотор, шатны хажууд хогоо тавьдаг байсан айлууд бүр сүүлдээ айлын хаалганы гадна хогоо авчраад шидчихдэг болчихсон байна шүү хэмээн хорш маань ярилаа. Нээрээ л бункер онгойлгоод хогоо хийх, доод давхар луу буугаад хогоо хаяхаасаа ч залхуурдаг хүмүүс олширч.

Үүнээс гадна нар, салхи үзэх зориулалт бүхий цонхоор хог хаяхыг хатуу хориглоно. Таны хаясан хог хэн нэгний амь нас, эрүүл мэнд, эд хоронгод хохирол учруулж болох юм шүү.

Хогтой холилдох уу, цэвэрхэн амьдрах уу гэдэг иргэн бүрийн хүчин чармайлтаас

шалтгаалдаг юм шvv. Дээр нь лифтэнд нусаа нийх, швлсээ хаях, орцонд тамхи татахыг “цээрлэх” хэрэгтэй.

“Гэр минь л цэвэрхэн байвал боллоо” гэж бодоод vдээрээ хогоо чулуудчихаад сууж байгаа очvvхэн бодол тань тун буруу гэдгийг дуулгая. Учир нь орц бол таны гэрийн нэг хэсэг юм. Орц чинь бохир байвал таны гэр хэчнээн цэвэрхэн байгаад нэмэргvй адилхан бохирлогдох, бохирын улмаас vcsэх овчинд адилхан л нэрвэгдэнэ.

Мон хорш тань орцондоо хог хаяж байвал хажуугаар нь дуугvй онгоролгvй зов шаардлагыг, эелдгээр тавиарай.

Хотын хvн танд амжилт хvсье.

СОЁЛЫН ДОВТОЛГОО №11: Хогийг зовхон хогийн саванд хаядаг.

Дээрх шог зураг амьдрал дээр олон тохиолддог. “Энэ хогийг яана аа, арай дэндvv юм аа” гэж уулга алддаг хэр нь хvний нvд хариулж байгаад хогоо чулуудчихдаг хvн олон. Олон гэж яаж мэдэж байгаа юм гэж vv. Хаашаа л харна хоглорч буй хогийг хараад л тэр.

Дээр нь боловсон, соёлтой байна гэдэг боловсрол эзэмшсэн дипломоор vнэлэгддэггvй. Ходооний хvн хотод ирээд бусдын тав тухыг бодоод хогоо халааслаад явж байхад, хэд хэдэн сургуулийн диплом овортолж, ганган сайхан хувцасласан мортлоо идсэн чихрийн цаас, уусан ундааныхаа савыг чулууддаг нэгэн бий.

Заавал бид бусдын хаясан хогийг тvvгээд л эх оронч, энэрэнгvй сэтгэлтэн, нийгмийн баатар болох гээд байх шаардлага байхгvй. Бид "тарьсан" хогоо оороо цэвэрлэхдэг, бусдад "хог битгий хаяач ээ" гэдгийг ойлгуулчихдаг бол л болох нь тэр. Тэгж чадвал Азийн цагаан дагина Улаанбаатарт амар сайхандаа жаргаж, аж тороод байна гэсэн vг.

1.Намар-самар-хог

Намар болохоор самар гараад, самар харахаар идмээр санагдаад байна уу. Идэж бололгvй яах вэ. Гэхдээ гэртээ хариад идэх хэрэгтэй. Намрын улиралд хамгийн их нvдэнд "хvйтэн" харагддаг хог бол самрын яс. Хаа сайгvй л хуруугаа хохож, хог "vйлдвэрлэсэн" хvмvvc. Эцэст нь хотын гудамж намрын шар навчсаар бус самрын ясаар "гоёж" байна. Ил задгай борлуулж буй самрыг угааж, цэвэрлэлгvй оороор хэлбэл гадаа идсэнээс болж гэдэсний халдварт овчин vvcэх шалтгаан болдог. Оорийгоо хордуулж, ороол бусдад таагvй сэтгэгдэл торvвлэн байж гадаа гудамжинд самар идэх шаардлагагvй. Бvр самар цомохгvй л бол тэсэхгvй байвал ядаж самрынхаа ясыг уутанд хийж байхыг зовлое.

2.Энд орох уу тэнд орох уу

Нэг vеэ бодвол нийслэл хотод маань хогийн сав олон болжээ. Харин хогийн саванд хог хийхдээ та нvдээ аньж байгаад шидчихдэг юм биш биз? Зарим хогийн сав хоёр тасалгаатай байдаг.

Дахивар ба энгийн гэсэн. Дахивар гэдэг нь дахин боловсруулж болох ундаа, усны сав. Харин энгийн бусад хог хаягдлыг хийдэг гэдгийг сануулахад гэмгvй болов уу. Хэрэв хоёр тасалгаатай хогийн савны бичиг нь арилсан бол ногоон тэмдэглэгээтэй хэсэг нь дахин боловсруулах харин улаан тэмдэглэгээтэй нь энгийн хог хаягдал хийх хэсэг нь юм шvv.

3.Миний машин ямар хогийн сав уу

Та арай ингэж бодож байгаа юм биш биз. Таны машин хогийн сав биш бол Улаанбаатарын гудамж, талбай бүр биш шүү. Ганган сайхан машиныхаа цонхоор ус ундааныхаа савыг чулуудаж байгаа бол Та их хотын соёлтой нэгэн хэрхэвч биш гэдгийг ойлгож, ухаарна уу.

Хотын хүн танд амжилт хүсье.

СОЁЛЫН ДОВТОЛГОО ХИЧЭЭЛ №12: Тагтнаасаа эсвэл цонхоороо дээж оргож болохгүй гэдгийг ЭЭЖДЭЭ ХЭЛЭЭРЭЙ.

Эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусын тулд хэмээн тэнгэр бурхандаа оргодог цай, сүүний дээж маань бусдын уур бухимдлыг торүүлж, монгоний гарлага болдог байж болохгүй.

Ямар сайндаа л орцны үүдэнд гуйсан, уурласан, занасан ил захидлууд ховорч байх вэ дээ.

Ёс заншил, уламжлалаа овлоно гэдэг сайн хэрэг. Гэвч суурин амьдралд нийцүүлэх шаардлагатай зүйлс гэж бий. Түүний нэг нь дээр дурдаад буй цайны дээж оргох ёс. Ингээд бичихээр яах гэж цонхны дор машинаа тавьдаг юм бэ гэх асуулт урган гарч магад. Тэгвэл сүүлийн үед барьсан, барьж буй, барих барилгууд ихэнхдээ байрныхаа дор зогсоолтой байх юм аа гэсэн хариулт байна.

Цонх, тагтнаасаа дээж оргож байгаа иргэд бусдын эд хоронгийг бохирдуулан,

бухимдлыг торvvлж байгаагаа ойлгож, ухааран гэрээсээ гарч ёсыг ёс чигээр нь вйлдэх хэрэгтэй. Энэ бол бас л нэг соёлын илэрхийлэл юм.

Нэмж хэлэхэд машин дээр дуссан сvvний толбо энгийн арчилтаар арилах нь ховор. Учир нь сvvний найрлаганд уураг, тос, лактоз мон бусад микро элементvvд байдаг учраас машин дээр толбо тогтож, угаалгын газар очихоос оор сонголт vлдээдэггvй гэдэгтэй жолооч нар санал нийлэх биз ээ.

Тиймээс ээждээ, эмээдээ цонхоороо болон тагтан дээрээсээ цацал оргох нь хотын соёлд нийцэхгvй тул болихыг хvсч, ярилцаарай.

Хотын хvн танд амжилт хvсье.

СОЁЛЫН ДОВТОЛГОО ХИЧЭЭЛ №13:

Драм болон дуурийн vзвэр vзэхэд мэдэж авах зvйлс нь кино vзэхээс илvvтэй тогтсон ёс байдаг учраас энэ талаар мэргэжлийн хvний зовлогоог хvргэж байна. Дуурь vзэхэд юуг анхаарах ёстой талаар “Имако” консалтинг институтын захирал Р.Лхагвадуламын ингэж зовлож байна.

Театрыг ариун сvм гэж нэрлэдэг. Театрт очих нь сэтгэлийг ариусгадаг. Хэдэн зууны турш язгууртан, ихэс дээдэс хvvхдээ ов тэгш хvмvvжvvлэх арга болгон театрыг сонгосон байдаг. Тэр ч утгаараа соёлт хvний заавал хийх ёстой вйлдлийн нэг нь театрт очих.

Театрт очсоноор хvний таван мэдрэхvй зэрэг ажилладаг. Яруу тунгалаг найрал хогжмийг сонсож чих баясна, тайзнаа байгаа чимэглэл, олон сайхан зvйлсийг харж нvд баясна. Бvх хvн хамгийн сайхан хувцсаа сайхан vнэртэнтэй хослуулдаг учраас vнэрийн найрал хогжим театрт таныг угтдаг. Мон театр бол танин мэдэхvйн ач холбогдолтой.

ТЕАТРТ ГАРГАДАГ АЛДААНУУД:

- Хоцорч ирдэг,
- Учир мэдэхгүй хvvхдээ авчирч уйлуулдаг,
- Хоол хvнсний зvйл авчирч (шарсан томс шажигнуулахаас эхэлнэ) тоглолтын дундуур иддэг,
- Хоорондоо ярих – За одоо Алтанхуяг бvжиглэх гэж байна, японд амьдарч байгаа юм уу Монголд амьдарч байгаа юм уу за яг одоо бvжиглэлээ шvv, гурав, доров, тав эргэчихлээ гэх мэтээр хоорондоо ярьдаг. Тухайн взвэрийн талаар сэтгэгдлээс эхлээд бvхий л зvйлийг дараа нь ярих хэрэгтэй.
- Хувцасны олгvvр хvн ихтэй болчихно гээд тvрvvлж гардаг. Найруулагч, жvжигчид гээд хамгийн оргил, ёсолгоо хийх вед нь бvгд гараад явчихдаг.
- Ихэнх театрууд утасны дуу намасгагч, долгион сааруулагчтай болсон хэдий ч та утсаа унтрааж, дууг нь хаах хэрэгтэй. Хоёр цаг взвэр взэхдээ л утсаа унтраах соёлтой байх хэрэгтэй. Мөн утсаа оролдох, жvжигчдийн зургийг авах, бичлэг хийхийг хатуу хориглодог.

Театрт очихдоо гоёх хэрэгтэй

Ихэнх хvмvvс ажлаасаа шууд очдоггvй аж. Тусгайлан бэлдэж, гоё сайхан болчихоод театрт очдог. Эрэгтэйчvvд эрвээхий зангиа, хослол, эмэгтэйчvvд даашинз омсож очих нь театрыг, оорийгоо, бусдыг хvндэлж буй нэг хэлбэр. Эмэгтэйчvvдийн хувьд нvvр будалтдаа вдшийн будалт сонгох хэрэгтэй. Театрт очих нь гэдэг бол взэгдэл. Тиймээс ч театрт оорийгоо харуулах гэж, бусдыг харах гэж очдог гэсэн vг гарсан байх.

Үзвэр эхлэхээс багадаа 30 минутын омно очоорой

Театрт взвэр взэх гэж байгаа бол та багадаа 30 минутын омно ирсэн байх шаардлагатай. 19.00 цагаас взвэрт 10 минутын омно ирэх нь хоцорсонд тооцогддог.

Театр vднээсээ, олгvvрээсээ эхэлдэг. Энэ бол оргvй хоосон vг биш. Хувцсаа олгvvрт огохоос эхлээд хvний хувийн соёл харагддаг учраас энэ vг гарчээ. Эрэгтэй хvнтэй хамт очсон эмэгтэй хувцсаа эрэгтэйдээ огч олгvvлдэг байна.

Ингээд театрыг тойрон взвэрийн талаар мэдээллийг сонирхож, тvvх уламжлалтай нь

танилцах нь мон л соёлын нэг илэрхийлэл юм.

Эхний хонх дуугарахад танхим руу ороорой

Үзвэр эхлэхээс омо гурван удаа хонх дуугардаг. Эхнийх дээр танхимд орж суудлаа эзлэх хэрэгтэй. Суудлын талаар мэдээлэл үүдний хэсэгт байдаг учраас тэндээс мэдээлэл авах нь орсны дараа суудал хайх зэргээр бусдад садаа болохгүй байхад тань тусална. Үүдний хоточ еронхийд нь аль хэсэгт суухыг зааж огдог ч суудлын талаар мэдээллийг урьдчилан авах нь танд илүү амар.

Суудалдаа суухдаа хvнгvй вeд театрт тайз руу харж явна, харин хvн суусан байвал тэдэн рvв харж, уучлалт гуйж зорох нь зvйтэй. Харин жvжигчид тайзнаа гарсан вeд тайзаа хvндлээд сууж байгаа хvмvвс рvв нуруугаа харуулж явдаг байна.

Байн байн алга таших нь бvдvвлэг

Үзэгдэл дунд алга таших нь тийм ч таатай бус. Нэгдvгээрт жvжигчдийн анхаарлыг сарниулахаас гадна дуурийн вeд ид оргил хэсгийг сонсуулахгvй байх магадлалтай.

Тогсголд нь туслах дvрээс эхлээд гол дvр бvгд гарч ирж ёсолдог. Энэ вeд тайз, жvжигчдийг хvндлээд босч алга таших хэрэгтэй.

Тогсголд нь хэлэхэд аливаа вйл ажиллагааны урилгыг сайтар анзаарах хэрэгтэй. Хувцасны онгийг заасан байдаг учраас анхаарахад илvүдэхгvй.

Хотын хvн танд амжилт хvсье.

СОЁЛЫН ДОВТОЛГОО ХИЧЭЭЛ №14: Кинотеатрт биднийг юу бухимдуулдаг вэ.

Алжаал, ядаргаагаа тайлах, анд найз, гэр бүлийнхэнтэй цагийг зугаатай онгорвүлэхээр кино, жүжиг, дуурь юу ч юм үзэж суутал хэн нэгний утасны хонх чанга гэгч нь “орилох” тэр мочийг үгээр хэлэхийн аргагвй.

Утас нь дуугарсан “эрхэм” дуудлагыг таслалгвй “Ярих боломжгвй байна. Дараа ярья” гэхэд таны уур бухимдал, гомдол, цохрол нэгэн зэрэг ходолж, хvvхэлдэйн кинон дээр гардаг уурын яндан шиг л болдог биз дээ?

Энэ мэтчилэн оноох амрах, сэтгэлийн таашаал эдлэх сайхан цаг хугацаа хэн нэгний бүдvvлэг, соёлгвй байдлаас болж нуран унах нь бий. Ингээд л уур хvрсэн тэр хэсэг цаг моч, тvvний дараах хэсэг хором ч утгагвй болдог гэдэгтэй та санал нийлэх байх. Тэгвэл бид энэ удаагийн хичээлээрээ кинотеатрт хэрхэн бусдад саад болохгвй байх талаар мэдээллийг хvргэж байна.

Яалт ч үгвй хоцорсон бол уучлалт гуйгаад, хvмvvсийн хажуугаар зорохдоо нvvрээ хvн рvv нь харуулж зорохийг хичээгээрэй

Театрт хvмvvсийг тавгвй болгодог хамгийн эхний зvйл бол ЦАГААСАА ХОЦРОХ. Яг сайхан тухлаад суучихсан, кино эхэлчихсэн байхад гэрэл тусгаад л орж ирнэ дээ. Тэгээд уучлаарай ч байхгвй бүр дээр нь яг нvvрэн дээр богсоо “наачихна” гээч. Хэрэв та кино үзэхээр шийдсэн бол аль болох цагаасаа хоцрохгвй байхыг хичээх хэрэгтэй. Яалт ч үгвй хоцорсон бол уучлалт гуйгаад, хvмvvсийн хажуугаар зорохдоо нvvрээ хvн рvv нь харуулж зорохийг хичээгээрэй.

ХҮҮХЭД ХАРАХ ХҮНГҮЙ БОЛ КИНО ҮЗЭХ ШААРДЛАГАГҮЙ. Ингэж хэлэхэд хатуудахгвй болов уу. Кино театрт тасалбар болон танилцуулга дээр хэдэн наснаас дээш хvн үзэх боломжтой талаар мэдээлэл байдаг. Гэвч зарим хvн том хvний кинон дээр бага насны хvvхэдтэйгээ орох, аймшгийн, адал явдалт гэх мэт дуу чимээ ихтэй кинонд нярай хvvхдээ дагуулан ирэх нь бий. Нялх хvvхэд нь дуу чимээнд дэрхийн цочиж уйлахтай та ч бас таарсан биз ээ. Энэ мэтчилэн асуудлаас болж нэг танхимд үзвэр үзэж буй хvмvvст

тухгвй байдал ввсдэг гэдгийг анхаарахад илвүдэхгвй.

Дараагийн звйл кинотеатрт орж ирсэн л бол УТАСНЫХАА ДУУГ ХААГААРАЙ. Дээр дурдсанчлан гэнэт л элдэв янзын утасны хонх “чарлаж”, аваад хэлж байгаа вг нь “Завгвй байна дараа ярья”. Хэрэв та утсаар ярих боломжгвй бол таслаад автоматаар хариу илгээх шийдлийг ухаалаг утас хэдийнэ олгочихсон шvv дээ.

Кинотеатрт бас нэг звйл внэхээр тавгвй байдлыг бий болгодог. Энэ нь СУУДЛЫН АРААС ОШИГЛОХ . Зай багатайн улмаас ийм звйл тохиолдоод байна уу эсвэл оор шалтгаан байна уу гэдгийг мэдэхгвй. Ямартай ч таны омно хvн сууж байгаа гэдгийг санаад аль болох холоороо урд талынхаа суудалд хврэхгвй байхыг хичээгээрэй.

Хэрэв та утсаар ярих боломжгвй бол таслаад автоматаар хариу илгээх шийдлийг ухаалаг утас хэдийнэ олгочихсон

Тогсголд нь ХОГ. Кино дууслаа та уусан ундааны сав, идсэн корныхоо хайрцгийг суудлынхаа дор “мартчихсан” юм биш биз. Мэдээж дараагийн вэвэрээс омно цэвэрлэгээ хийх нь ойлгомжтой хэдий ч та оорийнхоо тарьсан хогийг аваад гарах хаалганы дэргэдэх хогийн саванд хийчихвэл бусдад внэхээр сайхан санагдахаас гадна танд ч сайхан сэтгэгдэл влдэнэ гэдэгт итгэлтэй байна. Үзвэр дууссаны дараа гэрэл асахтай зэрэгцээд л чихцэлдчихнэ. Тvvний дараа танхим дvvрэн хог влдэж байгааг харах ямар “сэтгэл овтгосон” хэрэг гэдгийг хэлэхэд илвүдэхгвй болов уу.

За тэгээд амралтын одрвүд ч хаяанд ирлээ. Кино вэхээр шийдсэн бол бидний бэлтгэсэн бяцхан хичээлийг санахад илвүдэхгвй биз ээ.